



## ХҮНИЙ БАГА ЭМЧ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Ажилласан жилдээ 2-оос доошгүй удаа эрдэм шинжилгээ судалгааны ажилд дангаар болон бусадтай хамтран оролцож, мэргэжлийн сэтгүүл, илтгэлийн хураангуйн эх хувиар баталгаажуулсан байх;
2. Ажиллах хугацаандаа иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр зөвлөмж, санамж, гарын авлагыг боловсруулан баримт хавсаргасан байх;
3. Сум, багийн иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг /сургалт, сурталчилгаа, өдөрлөг, аян гэх мэт/ 2-оос доошгүй удаа зохион байгуулж, тайланг байгууллагын удирдлагаар баталгаажуулсан байх;
4. Үйлчлэх хүрээний иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны дүнг харьяа дээд шатны байгууллага, хөндлөнгийн этгээдээр гаргуулж тус тус хавсаргах.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шинэ технологи, шинэ бүтээл нэвтрүүлж, үр дүнг тооцон байгууллагын чанарын ололт амжилтын бүртгэлээр баталгаажсан байх;
2. Ахлах зэрэг хамгаалснаас хойш хугацаанд дангаар буюу бусад мэргэжилтэнтэй хамтран эрүүл мэндийн чиглэлээр 1-ээс доошгүй удаа илтгэл хэлэлцүүлж, эсвэл ажилдаа дүн шинжилгээ хийж хамт олноороо хэлэлцүүлэн, байгууллагын удирдлагаар баталгаажуулсан байх;
3. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр зөвлөмж, санамж, гарын авлага 2-оос доошгүйг боловсруулан ажилдаа ашиглаж, хэвлэл, мэдээлэл, сонин, сэтгүүлийн аль нэгэнд нийтлүүлэн баримт хавсаргасан байх;
4. Ахлах зэрэг хамгаалснаас хойш сум багийн иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг 3-аас доошгүй удаа /сургалт, сурталчилгаа, өдөрлөг, аян гэх мэт/ зохион байгуулж, тайланг байгууллагын удирдлагаар баталгаажуулсан байх;

5. Эрүүл мэндийн чиглэлээр шинэ санаа, оновчтой санал гарган, үйл ажиллагаандаа нэвтрүүлж, үр дүнг тооцон байгууллагын чанарын ололт амжилтын бүртгэлээр баталгаажсан байх;
6. Мэргэжил нэгт мэргэжилтэн болон эмнэлгийн бусад мэргэжилтнүүдэд зориулсан сургалт зохион байгуулах эсвэл оролцож, тайланг эмнэлгийн даргаар баталгаажуулсан байх ;
7. Шинээр төгссөн бага эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэнг дагалдуулан сургаж, туршлагажуулан эмнэлгийн даргаар баталгаажуулсан байх ;
8. Үйлчлэх хүрээний иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны дүнг харьяа дээд шатны байгууллага, хөндлөнгийн этгээдээр гаргуулж тус тус хавсаргах.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Мэргэжлийн дагуу ном товхимол, гарын авлага, CD, DVD зэргийн аль нэгийг гаргаж, зохиогчийн болон оюуны өмчийн эрх авсан байх эсвэл тухайн байгууллагын чанарын албаны ололт амжилтын бүртгэлээр баталгаажсан байх;
2. Тэргүүлэх зэрэг хамгаалснаас хойш хугацаанд дангаар буюу бусад мэргэжилтэнтэй хамтран эрүүл мэндийн чиглэлээр 3-аас доошгүй илтгэл хэлэлцүүлж байгууллагын удирдлага, мэргэжлийн сэтгүүл, илтгэлийн хураангуйн аль нэгээр баталгаажуулсан байх;
3. Орон нутгийн хэмжээнд сургалт, семинар зохион байгуулж, эмнэлгийн дарга, харьяа сумын удирдлагаар баталгаажуулсан байх;
4. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр зөвлөмж, санамж, гарын авлагыг боловсруулан, хэвлэл, мэдээлэл, сонин, сэтгүүлд нийтлүүлэн, баримт хавсаргасан байх;
5. Эрүүл мэндийн чиглэлээр шинэ санаа, оновчтой санал гарган, үйл ажиллагаандаа нэвтрүүлж, үр дүнг тооцон байгууллагын чанарын ололт амжилтын бүртгэлээр баталгаажсан байх;
6. Эрүүл мэндийн чиглэлээр төсөл, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хэрэгжүүлэхэд оролцсон байх;
7. Шинээр төгссөн бага эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэнг 5-аас доошгүйг дагалдуулан сургаж, туршлагажуулан эмнэлгийн даргаар баталгаажуулсан байх;
8. Үйлчлэх хүрээний иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны дүнг харьяа дээд шатны байгууллага, хөндлөнгийн этгээдээр гаргуулж тус тус хавсаргах.